



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

AMCHAM CSR

e-journal

Issue 14 / September 2024

NEW
EDITION



MSM PROGRESS CUP 2024



ӨМНӨХ ҮГ

Бид 2024 оны сүүлийн улирал дээр ирж байгаа энэ үед гишүүн байгууллагуудын компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн олон ажлууд Монголын бизнесийн эрүүл орчныг бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр байгааг уламжлахад таатай байна. "АмЧам Монгол" нь хариуцлагатай өсөлтийн гол тулгуур болох бизнесийн ёс зүйтэй үйл ажиллагаа, тогтвортой хөгжил, олон нийтийн оролцоог чухалчилсаар ирсэн.

CSR-e-Journal сэтгүүлийн энэ удаагийн дугаарт гишүүн байгууллагуудын ойрын саруудад хэрэгжүүлсэн үр дүнтэй санаачлагуудыг онцолж, тэдгээрийн нийгэмд үзүүлсэн бодит өөрчлөлтүүдийг багтаалаа. Ногоон эрчим хүчний төслүүдээс эхлээд ажиллах хүчний хүртээмжтэй хөгжил Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих, нийгмийн давхарга бүрт хүрч ажилласан олон сайхан хүчин чармайлтууд нь бидний нэгдмэл үнэ цэн, зорилго, алсын харааг илэрхийлдэг.

Тогтвортой байдал, компанийн ёс зүй, нийгмийн хөгжилд жишиг тогтоож буй компаниудын урам зориг өгсөн түүхийг та энэ дугаараас унших болно. Бид хамтдаа Монгол Улсын хөгжил цэцэглэлт, хүртээмжтэй ирээдүйн төлөө зүтгэж байгаа энэ үед тэдний туршлага бусдыг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд гүн гүнзгий оролцоход түлхэц болно гэж найдаж байна. Эерэг нөлөөллийг бий болгохын төлөө үргэлж зүтгэж байгаад баярлалаа!

Ерөнхий Редактор

Л. Эрдэнэбилэг

"БАДРАХ ЭНЕРЖИ" КОМПАНИ ОЛБОРЛОЛТЫН ШИНЭ ТЕХНОЛОГИЙН ТАЛААРХ ЭХНИЙ ЦУВРАЛ ЛЕКЦ, СЕМИНАРАА МУИС, ШУТИС-Д АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ ДУУСЛАА



Өнгөрөгч 3–4 дүгээр сард "Бадрах Энержи", "Орано Майнинг" компанийн экспертүүд газар доор уусган олборлох технологийн талаарх зургаан удаагийн цуврал лекц, семинарыг дотоодын их сургуулиудад зохион байгууллаа. Лекц, семинарт Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн нийт 35 эрдэмтэн багш, оюутан идэвхтэй оролцжээ.

Лекц семинараар газар доор уусган олборлох технологиор олборлолт явуулах боломжтой ордын геологийн тогтоц, онцлог, нөөцийн тооцоолол, олборлолтын үеийн байгаль орчин хамгаалал, компанийн нийгмийн хариуцлага, олон нийтийн дэмжлэг хийгээд нөхөн сэргээлт гээд олон сэдвийг хамарсан.

Цуврал лекц, семинарын хүрээнд оролцогчид "Бадрах Энержи" компанийн 2021-2022 онд хийсэн ураныг газар доор уусган олборлох үйлдвэрлэлийн туршилтын талбай, боловсруулах үйлдвэр мөн олборлосон байгалийн ураны бүтээгдэхүүн гээд олборлолт, боловсруулалтын бүхий л үе шаттай нарийвчлан танилцсан байна.

Зөөвч-Овоо төслийн менежер Эрмалъ Коплику: "Ирээдүйд хийгдэх үндсэн олборлолттой харьцуулахад хэмжээгээр бага ч туршилтын олборлолтын үйлдвэртэй семинарт оролцогчид газар дээр нь биечлэн танилцлаа. Ингэснээр ГДУО технологи, түүний нөлөө, ирээдүйн олборлолтын суурь зарчмын талаар ойлголт, мэдлэгтэй болж чадсан гэж бодож байна. Салбараа сайн мэддэг, шинэ зүйлд нээлттэй сэтгэлгээгээр ханддаг зочдыг төслийн талбай дээрээ хүлээн авахад тун таатай байлаа," хэмээн онцолсон юм.

Газар доор уусган олборлох аргыг "Бадрах Энержи" компани Монгол улсын уул уурхайн салбарт анхлан нэвтрүүлж байгаа билээ. Тиймээс төслийн бүх оролцогч талууд газар доор уусган олборлох технологийн талаар сайтар ойлголттой байх нь "нийгмийн лиценз" авахад чухал ач холбогдолтой юм.

Компани нь МУИС, ШУТИС болон Сайншанд дахь Политехникийн коллежтой хамтын ажиллагааны санамж бичгийг өнгөрөгч 2023 онд байгуулсан. Санамж бичигт тусгасан ажлууд ийнхүү эхнээсээ бодит ажил болж байна.



КАПИТРОН БАНКНЫ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД



Тайлант хугацаа: 2024.01–08 сар

Капитрон банк нь үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын банк, санхүүгийн системд тогтвортой өсөлттэй ажиллаж, банкны санхүүгийн үзүүлэлтүүд жил бүр тогтмол өсч, банкны системд эзлэх байр сууриа улам бэхжүүлсээр байна.

Түүнчлэн банк нь нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд нийгэм, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой төсөл, хөтөлбөрүүд, соёл урлаг, спортын олон үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж, ёс зүйтэй, хариуцлагатай аж ахуйн нэгжийн үүргээ биелүүлсээр ирлээ. Хүрээлэн буй орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой ногоон зээл, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл гэх мэт бүтээгдэхүүнийг харилцагчдадаа санал болгодог. Тайлант 2024 онд Капитрон банкны компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд хийж, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн мэдээллийг хүргэж байна.

"МАЛЧДАДАА ТУСАЛЪЯ" АЯН

Монгол Улсын Засгийн газраас зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор 2024 оны гуравдугаар сард өрнүүлсэн "Малчдадаа тусалъя" аянд банкны ажилтнуудаас ОБЕГ-ын шилэн дансанд цугласан нийт хандивыг банкны зүгээс хоёр дахин нэмэгдүүлж, хүлээлгэн өгөв.



"Малчдадаа тусалъя"

Шилэн дансанд цугларсан хандивыг 2 дахин нэмэгдүүлэн ОБЕГ-т хүлээлгэн өглөө.



"JUNIOR INTERNSHIP PROGRAM 2024" ХӨТӨЛБӨР

Зориг сангаас залуусын боловсролыг дэмжих зорилтын хүрээнд хэрэгжүүлдэг Junior Internship Program (JIP) буюу "Залуу дадлагажигч" хөтөлбөрийн Ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажиллав.

Тус хөтөлбөр нь энэ оны дөрөвдүгээр сард хэрэгжсэн бөгөөд ЕБС-ийн 10, 11 дүгээр ангийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн сургалтуудад хамрагдах, өөрийн хүссэн мэргэжлийн чиглэлээр байгууллага дээр богино хугацааны танилцах дадлага ажил хийх боломжийг олгодог хөтөлбөр юм.

"ТЭРБУМ МОД" ӨДӨРЛӨГТ НЭГДЛЭЭ

Монгол Улсад банкны тогтолцоо үүсэж, бэхэжсэний 100 жилийн ойг тохиолдуулан тавдугаар сард Монголбанк, Монголын Банкны Холбоо, арилжааны банкууд болон "Тэрбум мод" сангаас хамтран Гачууртад байрлах Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнд нарс, шинэс, гацуур зэрэг нэр төрлийн 1000 гаруй модны тарьц суулгахад Капитрон банкны хамт олон нэгдлээ.



"БАНКИР ОЮУТАН" ХӨТӨЛБӨР

Капитрон банкны зүгээс оюутан залуусын ажлын гараа, анхны алхмаа хийхэд туслах зорилгоор "Банкир оюутан" хөтөлбөрийг дөрөв дэх жилдээ хэрэгжүүллээ.

Тус хөтөлбөр нь оюутан залууст сурч, эзэмшиж буй мэргэжлээрээ ажлын туршлага хуримтлуулж, байгууллагын соёлд суралцан, салбарын мэргэжилтнүүдээс туршлага судалж, банканд ашиглагддаг программууд дээр дадлага хийх боломжийг олгодог юм. Энэ жил тус хөтөлбөрийн хүрээнд 10 оюутан шалгарч, зургаадугаар сараас банкны 8 газар, хэлтэст өөрсдийн сонирхсон чиглэлээр хоёр сарын хугацаанд цалинтай дадлага хийж, туршлага хуримтлууллаа.

"ЖИНЖИЙ МАЙНИНГ" ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон найман мянган га талбайг нөхөн сэргээнэ" зорилтын хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт байрлах уул уурхайн улмаас эвдэгдэж олон жил орхигдсон нийт 800.0га талбайг нөхөн сэргээх ажилд "Жинжий майнинг" ХХК-тай хамтран үндсэн санхүүжүүлэгчээр ажиллалаа.

Капитрон банк нь байгаль орчны нөхөн сэргээлтийг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөл, хөтөлбөрүүд, ногоон бизнесийг дэмжих чиглэлд тууштай хамтран ажилладаг.

ЛОРИНЭТ БОЛОН КРИСТИНА НОБЛИЙН ХҮҮХДИЙН САНГУУД ХАМТРАН СУРГАЛТ-ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГАД СУРЧ, ХҮМҮҮЖИЖ БУЙ ӨСВӨР ХҮҮХДҮҮДИЙН БОЛОВСРОЛ, ХӨГЖЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАЖ БАЙНА



Лоринэт Сан нь Монгол Улсад туслалцаа дэмжлэг шаардлагатай байгаа хүүхэд залуус, айл өрхүүдийн амьдралд тогтвортой, эерэг өөрчлөлтийг бий болгох үндсэн зорилготой. Энэхүү эрхэм зорилгын хүрээнд бид дараах хоёр чиглэлд дэмжлэг үзүүлж ажилладаг. Үүнд:

Бага насны хүүхдийн асаргаа халамж, боловсрол

Бага насны хүүхдүүдэд асран халамжлуулах, насандаа тохирсон эрт үеийн боловсрол эзэмших боломжийг бий болгох.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

Залуучуудад тогтвортой хөдөлмөр эрхлэх, орлого болон амьдралын чанараа сайжруулах боломжийг бий болгох.

Бидний дэмжлэг үзүүлж буй аргачлал

Лоринэт Сан нь Монгол Улсад нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх шинэлэг арга аргачлал нэвтрүүлж буй төсөл хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулж, тэдгээрийг хэрэгжүүлдэг байгууллагуудад санхүүгийн болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн үр нөлөө бий болгодог.

Бид бүтээж буй нийгмийн үр нөлөөний цар хүрээгээ тэлэх зорилгоор бусад ижил төстэй сан, хувь хүн, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран, Монгол Улс руу болон дотооддоо нийгмийн хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэхээр зорин ажилладаг.




КРИСТИНА НОБЛИЙН ХҮҮХДИЙН САН

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд Лоринэт Сан нь Кристина Ноблийн Хүүхдийн Сангийн хэрэгжүүлдэг Өсвөр насныхны хөгжлийн хөтөлбөрийг дэмжиж ажиллахаар болсон билээ.

ШИЙДВЭРЛЭХЭЭР ЗОРЬСОН АСУУДАЛ

Бусад улс орнуудын адилаар Монгол Улсад гэмт хэрэг, зөрчилд холбогдон ял шийтгэл авсан өсвөр насны хүүхдүүдийг цогц байдлаар засан хүмүүжүүлэх, тэдний нийгэмшихүйг дэмжихэд чиглэсэн үр дүнтэй арга барил, цогц үйл ажиллагаа дутмаг хэвээр байна. Ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгэм-эдийн засгийн олон төрлийн сөрөг хүчин зүйлээс хамаарч өсвөр насны хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох, давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй байдаг. Мөн ял, шийтгэл эдэлсний дараа гэр бүл болон олон нийтээс ирэх сөрөг хандлагаас үүдэн сэтгэлзүйн хувьд олон саад, бэрхшээлтэй тулгарч байдаг.





ШИЙДЭЛ

Кристина Ноблийн Хүүхдийн Сан нь 1997 оноос хойш "Боловсрол" хөтөлбөрийнхөө хүрээнд Монгол Улс дахь цор ганц, насанд хүрээгүй хүмүүсийн хорих анги буюу Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад сурч, хүмүүжиж буй 14–19 насны эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн боловсрол, хөгжлийг бүх талаар дэмжин ажиллаж байна.

Лоринэт Сан нь тус сантай хамтран эдгээр хүүхдүүдийг нийгэмд амжилттай эргэн нэгтгэж, ур чадвар болон сэтгэлзүйн эрүүл мэндийг нь цогц байдлаар дэмжих замаар амьдралаа итгэл дүүрэн шинээр эхлүүлж, нийгэмд эерэг хувь нэмэр оруулах, хариуцлагатай иргэн болж төлөвшихөд нь туслах зорилготой "Өсвөр насныхны хөгжлийн хөтөлбөр" буюу YRR хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллахаар боллоо. Тус хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр Монгол Улсад өсвөр насны хүүхдүүдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдох, мөн давтан гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах ач холбогдолтой юм. Үүнийг дараах үндсэн зорилтуудын хүрээнд хэрэгжүүлж байна. Үүнд:

- **Боловсрол** – мэргэжлийн сургалтуудаар дамжуулан хүүхдүүдэд техникийн ур чадвар олгох, тусгай сургалтын хөтөлбөрийн хүрээнд зөөлөн ур чадвар олгох, улмаар эдийн засгийн хувьд бие даасан, ур чадвартай боловсон хүчин болгох
- **Сэтгэлзүйн үйлчилгээ** – урлагийн сэтгэл засал болон бусад шинэлэг арга зүйгээр дамжуулан хүүхэд бүрийн онцлогт

тохирсон үр дүнтэй сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх

- **Олон нийтийг чадавхжуулах** – нийгэмшихүйг дэмжих зорилгоор гэр бүл болон олон нийттэй хамтран ажиллаж, сөрөг хандлагыг бууруулах, эрсдэлд ороход ойр байгаа хүүхдүүдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- **Хамтын ажиллагаа** – төрийн, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагууд, судалгааны төвүүд, хүний эрхийн байгууллагуудтай хамтарч, дээрх өсвөр насны хүүхдүүдийн хөгжил, нийгэмшихүйг дэмжихэд олон талт хамтын ажиллагаа өрнүүлэх
- **Нийгэмшихүйг дэмжих** – эдгээр хүүхдүүд нийгэмд эргэн хөл тавихад нь бүх талаар дэмжлэг үзүүлж, улмаар давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлж, хувь хүн болон нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэх.

Бидэнтэй хамтарч ажиллахыг хүсвэл доорх хаягаар холбогдоно уу

Кристина Ноблийн Хүүхдийн Сан –
mongolia@cncf.mn болон <https://www.cncf.org/>

Лоринэт Сан – info@lorinetfoundation.org
болон <https://www.lorinetfoundation.org/>

MSM AND PARTNERS ГОЛЬФИЙН ТЭМЦЭЭН НИЙГМИЙН ТӨСӨЛД ХАНДИВ ЦУГЛУУЛЛАА



MSM Группээс хамтран ажилладаг харилцагч, түншүүдийн дунд уламжлал болгон зохион байгуулдаг MSM and Partners гольфийн тэмцээн арга хэмжээг зохион байгуулан, тэмцээний оролцогчид нийгмийн төсөлд зориулах хандивыг цуглууллаа.

Арга хэмжээний хүрээнд МСМ Группийн харилцагч, түншүүд ур чадвар, цэц мэргэнээ сорихын хамт мөн нийгмийн сайн үйлсийн төсөлд хандив цуглуулан хандивладаг билээ. Бид өмнөх жилийн тэмцээний хандивын дүнг орон нутгийн болон хотын алслагдсан бүсүүдийн хүүхдүүдэд үнэ төлбөргүй шүдний эмчилгээ хийж, эрүүл мэндийн боловсрол олгодог Мишээл Кидс Хүүхдийн санд хандивлаж байсан билээ. Энэ жилийн хандивыг бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих төсөлд хандивлах юм.

МСМ ГРУПП "ТЭРГЭНЦЭРТЭЙ БААТРУУД PROGRESS CUP 2024" ТЭМЦЭЭНИЙГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МСМ Групп "Тэргэнцэртэй баатрууд Progress Cup 2024" тэмцээнийг JCI Progress салбар байгууллага болон Монголын Тэргэнцэртэй Сэлмийн Холбоотой хамтран МСМ Автомотив үзэсгэлэнгийн танхимд амжилттай зохион байгууллаа.

Тэргэнцэртэй туялзуур сэлмийн спортын "Тэргэнцэртэй баатрууд" төслийг 2019 оноос хойш JCI Progress салбар байгууллага Монголын Тэргэнцэртэй Сэлмийн Холбоотой



хамтран хэрэгжүүлж ирсэн бөгөөд анх гурван тамирчинтай эхэлж байсан уг төсөл өдгөө 60 орчим тамирчидтай болж, үйл ажиллагаа нь өргөжин тэлсээр тив дэлхийн тэмцээн уралдаанд эх орныхоо нэрийг гаргаж, амжилт дагуулсаар байгаа амжилт бүхий төсөл билээ. МСМ Групп нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд олон төсөл хөтөлбөрийг дэмжин хамтран ажиллагдийн нэг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд оролцох тэгш оролцоог хангах, дэмжин ажиллах юм.

МСМ ГРУПП АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ЗҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН MSMENTAL CARE ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА



Сэтгэл зүйн эрүүл мэнд биеийн эрүүл мэнд шиг чухал байдаг. Тиймээс МСМ Групп 2024 оныг ажилтнуудынхаа сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарах жил болгож 2 удаагийн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг үнэ төлбөргүй авч, сургалтад хамрагдаж, сэтгэл зүйн талаар мэдээллүүдийг тогтмол авах MS Mental Care хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд улирал бүр сэтгэл зүйн эрүүл мэндтэй холбоотой сургалтыг "Сэтгэц оношилгоо, сэтгэл зүйн төв"-өөс ажилтнуудад хүргэж байгаа бөгөөд мөн ажилтнууд анхан болон давтан гэсэн 2 удаагийн ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөөг аван сэтгэл зүйн эрүүл мэнддээ анхаарч байна.

МСМ ГРУПП ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН НИЙСЛЭЛИЙН 116-Р СУРГУУЛЬД УРЛАГИЙН ТАНХИМЫН САНДАЛ ХАНДИВЛАЛАА




МСМ Групп нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд харааны бэрхшээлтэй хүүхдийн Нийслэлийн ерөнхий боловсролын 116-р сургуулийн урлагийн танхимд 30 ширхэг сандал хандивлалаа. 116-р сургууль нь харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд тусгай хэрэгцээт боловсрол олгодог нийслэлийн ерөнхий боловсролын сургууль юм. Харааны бэрхшээлтэй сурагчид нь сонсох болон дуулах, шүлэг унших зэрэг урлагийн олон төрлийн авьяастай байдаг билээ. МСМ Групп суралцагч бүрийн оролцоо, хүртээмжийг сайжруулах зорилгоор урлагийн танхимын сандал хандивлалаа.

МСМ ГРУПП Д.НАЦАГДОРЖИЙН МУЗЕЙГ СЭРГЭЭН ЗАСАХ ТӨСЛИЙГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА

МСМ Групп нь Монголын суут зохиолч, яруу найрагч, түүхч, соён гэгээрүүлэгч Дашдоржийн Нацагдоржийн музейг сэргээн засварлаж нээх Монголын Зохиолчдын Эвлэлийн (МЗЭ) төслийг дэмжин ажиллалаа.

МЗЭ нь 2026 онд тохиох Д.Нацагдоржийн мэндэлсний 120 жилийн ойг тохиолдуулан 1990 онд хаагдаад байсан Д.Нацагдоржийн музейг сэргээн засаж, нээх төслийг эхлүүлээд байна. Тус төслийн хүрээнд МСМ Группээс музейн үзмэрүүдийг бүртгэх, соёлын өвийн мэдээллийн цахим санд оруулах, цахим фото сан үүсгэх зэрэг ажилд хандив үзүүлж дэмжин ажиллалаа.



МСМ ГРУПП ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХОЛБООГ ДЭМЖИН АЖИЛЛАЛАА



Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй
Эцэг Эхчүүдийн Холбоо

МСМ Групп нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоог (ХБХЭЭХ) дэмжин ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эрхийг хамгаалах, тэднийг нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэн ажилладаг юм.

Тус холбоо нь жил бүрийн хүүхдийн баяраар гишүүдийнхээ дунд хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгуулдаг ба МСМ Группээс хүүхдийн баярын бэлгийн багцад хандив өгөн, хамтран ажиллалаа.

ЮНЕСКО БОЛОН РИО ТИНТО ГРУПП МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

RioTinto

ЮНЕСКО болон Рио Тинто групп Монгол Улсад тогтвортой хөгжлийн санаачилгыг дэмжих зорилгоор урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.

Хамтын ажиллагааны хүрээнд талууд юун түрүүнд гурван жилийн хугацаанд "Соёлын болон геологийн өвөөр дамжуулан Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх нь" төслийг хэрэгжүүлэх бөгөөд уг төсөлд Рио Тинто Монгол ХХК нийт 1.5 сая ам.долларын санхүүжилт хийнэ. Уг төслийг ЮНЕСКО-гийн Бээжин дэх төлөөлөгчийн газар болон Монгол Улс дахь баг нь хамтран хэрэгжүүлэх юм. Монгол Улсад соёлын болон

гео-өвийн санаачилгуудаар дамжуулан тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн энэхүү төсөл нь Соёлын өвийн менежмент ба чадавхыг бэхжүүлэх, ЮНЕСКО-д бүртгэлтэй гео-паркийг байгуулах, мэдлэгийн менежмент болон сурталчилгааг дэмжих, цаашид өргөжин тэлэх боломжийг бий болгохыг зорих юм.





Дээрх хамтын ажиллагаа нь хоёр байгууллагын хамтын туршлага, нөөц бололцоог ашиглах замаар геологийн шинжлэх ухааныг хөгжүүлж Монгол Улс дахь анхны гео-паркийг ЮНЕСКО-д бүртгүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Тус түншлэлийн хүрээнд ЮНЕСКО болон Рио Тинто групп үндсэн гурван чиглэлээр хамтран ажиллана:

Тогтвортой аялал жуулчлал: Монгол Улсын тогтвортой туршлагыг дотоод болон гадаадад сурталчлах, соёл, байгалийн өвийг хамгаалах, хамгаалахын ач холбогдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлт: Талууд өөрсдийн хосолсон туршлагаа ашиглан Монгол Улсад байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн менежментийн сайн туршлагыг дэмжин ажиллана.

Чанартай боловсрол: ЮНЕСКО болон Рио Тинто нь өндөр чанартай, тэгш, хүртээмжтэй мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын (МБС) хөтөлбөрүүдийг хангахаар, Рио Тинто компанийн тус салбарт өмнө оруулсан хөрөнгө оруулалт дээр түшиглэн ажиллана. Талууд Монголын шинэ үеийнхэнд тусгай техникийн ур чадвар, мэдлэг олгох замаар улс орон даяар тогтвортой өсөлт, нийгэм, эдийн засгийн дэвшлийг бий болгохыг зорьж байна.

МОНГОЛЧУУД МОНГОЛЧУУДДАА ХӨТӨЛБӨР



Дэлхийн Зөн Монгол ОУБ нь 2018 оноос эхлэн Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийг нийгэмд өгөх соёлыг түгээн дэлгэрүүлэх, хувийн хэвшил, орон нутгийн түншлэгчид, сайн дурынхны оролцоо, дэмжлэгтэйгээр нийгмийн тусламж нэн шаардлагатай хүүхдүүдийг хамгаалах, тэдний оролцоо, хөгжилд хувь нэмэр оруулах, улмаар хүүхдүүдийг өөртөө итгэлтэй, мөрөөдөлтэй бие хүн болгон төлөвшүүлж, нийгмийн боломжийг тэгш хүртээх зорилгоор хэрэгжүүлж байна.

2,671

хүүхдүүд хөтөлбөрт
бүртгэлтэй

1,500

хүүхдүүд ивээн
тэтгэгчтэй болсон





Хүүхэд хамгаалал: Эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийнхныг "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга"-д суралцуулснаар хүүхэд хамгаалагдсан орчинд амьдрах нөхцөлийг нь бүрдүүлж өгдөг.



Хүүхэд хөгжил, оролцоо: Орон нутгийн сургууль дээр суурилсан хөгжлийн клуб, дугуйлангуудаар дамжуулан хөтөлбөрийн хүүхдүүдийг өөртөө итгэлтэй, ур чадвартай, мөрөөдөлтэй бие хүн болгон төлөвшүүлдэг.



Амьжиргаа дэмжих: Хүүхдүүдийн гэр бүлийг "Төгсөлтийн аргачлал" хөтөлбөрт хамруулж санхүүгийн мэдлэг ур чадвар, зөв дадалд сурган, өрхийн бизнесээ эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг.



"Өмнө нь уулзаж байгаагүй, огт танихгүй хүн надад итгэж, манай гэр бүлийн амьжиргаанд бодитой өөрчлөлт гарахад тусалж байгаа нь Монголчууд Монголчууддаа хөтөлбөрийн үр шим юм даа"

Б. ЭРДЭНЭЧИМЭГ
Өрхийн хүлэмжийн бизнес эрхлэгч

